



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/189/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19-20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН НОМГОН
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.МАРТ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/189/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 22,448.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	163,957,740.75	247,421,917.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	116,295,640.43	194,984,759.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	116,295,640.43	194,984,759.03
3121	Төгрөг	116,295,640.43	194,984,759.03
31211	Төрийн сангийн харилцах	116,295,640.43	194,984,759.03
35	БАРАА МАТЕРИАЛ	47,662,100.32	52,437,158.32
351	Түүхий эд материал	47,000.00	
3513	Эм боох материал	47,000.00	
354	Хангамжийн материал	47,615,100.32	52,437,158.32
3542	Аж ахуйн материал	18,868,950.00	20,522,250.00
3547	Бусад хангамжийн материал	28,746,150.32	31,914,908.32
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	804,801,148.73	1,111,988,699.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	804,801,148.73	1,111,988,699.85
392	Биет хөрөнгө	789,766,548.57	1,097,204,099.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	838,239,069.67	1,075,220,858.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	(203,274,748.50)	(243,900,422.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.00)	(14,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	160,078,182.40	296,849,162.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,407,658.00)	(89,422,510.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,375,643.70	69,391,643.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,499,341.44)	(40,720,507.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,247,671.00	22,247,671.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,206,004.13)	(9,106,004.21)
39217	Ном	16,213,733.87	16,644,208.37
393	Биет бус хөрөнгө	15,034,600.16	14,784,600.20
39301	Програм хангамж	1,768,000.00	1,768,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,517,999.84)	(1,767,999.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,784,600.00	14,784,600.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	968,758,889.48	1,359,410,617.20
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		70,481,448.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		70,481,448.00
413	Өглөг		70,481,448.00
4136	Бусад өглөг		70,481,448.00
41361	Байгууллагад төлөх өглөг		70,481,448.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	968,758,889.48	1,288,929,169.20
51	Засгийн газрын хувь оролцоо	968,758,889.48	1,288,929,169.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	396,512,915.71	396,512,915.71
512	Хуримтлагдсан үр дүн	(123,927,156.83)	196,243,122.89
5121	Өмнөх үеийн үр дүн	(123,927,156.83)	(123,927,156.83)
5122	Тайлант үеийн үр дүн		320,170,279.72
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	696,173,130.60	696,173,130.60
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	968,758,889.48	1,359,410,617.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,109,202,537.71	1,773,141,410.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,616,409.16	273,338,101.50
120	Нийтлэг татварын бус орлого	41,616,409.16	273,338,101.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,132,100.00	2,236,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,097,100.00	2,061,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	37,811,404.70	267,933,043.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,672,904.46	3,168,758.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,067,586,128.55	1,499,803,308.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	933,471,300.00	1,327,653,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	933,471,300.00	1,327,653,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,562,590.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,562,590.00	10,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	132,552,238.55	162,149,608.93
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,552,238.55	162,149,608.93
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,003,882,103.89	1,452,971,130.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,003,882,103.89	1,452,971,130.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	959,015,673.89	1,407,186,810.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,721,395.94	969,550,808.00
210101	Үндсэн цалин	433,296,521.94	572,340,787.00
210102	Нэмэгдэл	156,906,803.00	354,040,021.00
210104	Урамшуулал	30,518,071.00	43,170,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,120,380.00	117,340,627.00
210201	Тэтгэврийн даатгал	52,779,853.00	80,511,957.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,209,433.00	9,714,158.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,967,540.00	7,234,979.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,100,832.00	2,070,279.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,062,722.00	17,809,254.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,040,338.55	147,357,008.93
210301	Гэрэл, цахилгаан	11,815,164.55	13,874,256.93
210302	Түлш, халаалт	92,577,200.00	120,384,736.00
210303	Цэвэр, бохир ус	13,647,974.00	13,098,016.00
2105	Нормативт зардал	31,865,900.00	29,668,130.00
210502	Хоол, хүнс	31,865,900.00	29,668,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,657,300.00	14,792,600.00
210604	Урсгал засвар	15,657,300.00	14,792,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,963,693.63	11,545,979.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,949,500.00	2,138,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,014,193.63	9,407,079.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,646,665.77	116,931,657.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,520,660.00	35,053,564.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,980,800.00	7,866,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,145,205.77	74,011,692.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,866,430.00	45,784,320.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,866,430.00	45,784,320.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,293,030.00	31,192,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,573,400.00	14,591,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	105,320,433.82	320,170,279.72
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	105,320,433.82	320,170,279.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,069,718,228.55	1,502,039,608.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,132,100.00	2,236,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,132,100.00	2,236,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,132,100.00	2,236,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,097,100.00	2,061,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	175,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,067,586,128.55	1,499,803,308.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	933,471,300.00	1,327,653,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	933,471,300.00	1,327,653,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,562,590.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,562,590.00	10,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	132,552,238.55	162,149,608.93
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,552,238.55	162,149,608.93
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	939,736,898.12	1,421,810,490.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	939,736,898.12	1,421,810,490.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	894,822,058.12	1,374,926,810.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,721,395.94	969,550,808.00
210101	Үндсэн цалин	433,296,521.94	572,340,787.00
210102	Нэмэгдэл	156,906,803.00	354,040,021.00
210104	Урамшуулал	30,518,071.00	43,170,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,120,380.00	117,340,627.00
210201	Тэтгэврийн даатгал	52,779,853.00	80,511,957.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,209,433.00	9,714,158.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,967,540.00	7,234,979.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,100,832.00	2,070,279.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,062,722.00	17,809,254.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,040,338.55	147,357,008.93
210301	Гэрэл, цахилгаан	11,815,164.55	13,874,256.93
210302	Түлш, халаалт	92,577,200.00	120,384,736.00
210303	Цэвэр, бохир ус	13,647,974.00	13,098,016.00
2105	Нормативт зардал	31,817,490.00	28,568,770.00
210502	Хоол, хүнс	31,817,490.00	28,568,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,511,900.00	14,792,600.00
210604	Урсгал засвар	14,511,900.00	14,792,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,963,693.63	19,925,244.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,949,500.00	2,138,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,014,193.63	17,786,344.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,646,860.00	77,391,751.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,816,060.00	68,225,351.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,830,800.00	9,166,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,914,840.00	46,883,680.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,914,840.00	46,883,680.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,341,440.00	32,292,080.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,573,400.00	14,591,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	129,981,330.43	80,229,118.60
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,451,500.00	1,540,000.00
	Дотоод эх үүсвэрээр	29,451,500.00	1,540,000.00
223001	Бусад хөрөнгө	29,451,500.00	1,540,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(29,451,500.00)	(1,540,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	100,529,830.43	78,689,118.60
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		116,295,640.43
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		194,984,759.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	(123,927,156.83)	968,758,889.48
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			320,170,279.72	320,170,279.72
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	196,243,122.89	1,288,929,169.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,618,435,400.00	1,423,350,490.33	195,084,909.67	88.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,618,435,400.00	1,423,350,490.33	195,084,909.67	88.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,568,245,100.00	1,376,466,810.33	191,778,289.67	87.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,100,242,400.00	969,550,808.00	130,691,592.00	88.1
210101	Үндсэн цалин	693,344,500.00	572,340,787.00	121,003,713.00	82.6
210102	Нэмэгдэл	387,108,300.00	354,040,021.00	33,068,279.00	91.5
210104	Урамшуулал	19,789,600.00	43,170,000.00	(23,380,400.00)	218.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,530,200.00	117,340,627.00	20,189,573.00	85.3
210201	Тэтгэврийн даатгал	93,520,600.00	80,511,957.00	13,008,643.00	86.1
210202	Тэтгэмжийн даатгал	11,002,500.00	9,714,158.00	1,288,342.00	88.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,501,100.00	7,234,979.00	(1,733,879.00)	131.5
210204	Ажилгүйдлийн даатгал	5,501,100.00	2,070,279.00	3,430,821.00	37.6
210205	Эрүүл мэндийн даатгал	22,004,900.00	17,809,254.00	4,195,646.00	80.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,652,400.00	147,357,008.93	6,295,391.07	95.9
210301	Гэрэл, цахилгаан	19,038,000.00	13,874,256.93	5,163,743.07	72.9
210302	Түлш, халаалт	120,393,600.00	120,384,736.00	8,864.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	14,220,800.00	13,098,016.00	1,122,784.00	92.1
2105	Нормативт зардал	48,911,700.00	28,568,770.00	20,342,930.00	58.4
210502	Хоол, хүнс	48,911,700.00	28,568,770.00	20,342,930.00	58.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,792,600.00	14,792,600.00		100.0
210604	Урсгал засвар	14,792,600.00	14,792,600.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,608,400.00	19,925,244.60	4,683,155.40	81.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,216,500.00	2,138,900.00	77,600.00	96.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,391,900.00	17,786,344.60	4,605,555.40	79.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,507,400.00	78,931,751.80	9,575,648.20	89.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,341,000.00	69,765,351.80	9,575,648.20	87.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,166,400.00	9,166,400.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,190,300.00	46,883,680.00	3,306,620.00	93.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,190,300.00	46,883,680.00	3,306,620.00	93.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,598,700.00	32,292,080.00	3,306,620.00	90.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,591,600.00	14,591,600.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,618,435,400.00	1,502,039,608.93	116,395,791.07	92.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,449,990,400.00	1,337,653,700.00	112,336,700.00	92.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,449,990,400.00	1,327,653,700.00	122,336,700.00	91.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,000,000.00	(10,000,000.00)	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00	(10,000,000.00)	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	168,445,000.00	162,149,608.93	6,295,391.07	96.3
132001	Орон нутгийн төсвөөс	168,445,000.00	162,149,608.93	6,295,391.07	96.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		2,236,300.00	(2,236,300.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,061,300.00	(2,061,300.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		175,000.00	(175,000.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		116,295,640.43	(116,295,640.43)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		194,984,759.03	(194,984,759.03)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Амжилттай суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх,
- Зөв харилцаа хандлагад төлөвшүүлэх,
- Эрүүл зөв дадал хэвшүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 390,651.7 мянган төгрөгөөр буюу 40.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	116,295.6	194,984.8	78,689.2
Авлага	-	-	-
Бараа материал	47,662.1	52,437.1	4,775.0
Үндсэн хөрөнгө	804,801.2	1,111,988.7	307,187.5
Нийт хөрөнгө	968,758.9	1,359,410.6	390,651.7
Өр төлбөр	-	70,481.4	70,481.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	968,758.9	1,288,929.2	320,170.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	968,758.9	1,359,410.6	390,651.7

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 194,984.8 мянган төгрөг болж 78,689.2 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас;
- Бараа материалын дансны үлдэгдэл 52,437.1 мянган төгрөг болж 4,775.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 95,807.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 3,168.7 мянган төгрөгийн сурах бичгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үйл ажиллагаанд 94,201.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,111,988.7 мянган төгрөг болж 307,187.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 113,266.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Боловсролын газраас 13,549.5 мянган төгрөгийн ном, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 236,981.7 мянган төгрөгийн сургуулийн барилгын дээвэр болон хичээлийн байрны 1 давхрын коридорын шалны их засварын ажил хийгдэж капиталжуулан бүртгэж, тайлант онд 74,011.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 70,481.4 мянган төгрөгөөр өссөн нь 48 сарын хугацаатай лизингээр Мэксим консалтинг ХХК-аас нийлүүлэгдсэн цахим ангийн хэрэглэгдэхүүний 63,748.0 мянган төгрөг, 24 сарын хугацаатай лизингээр Юнивишн ХХК-аас нийлүүлэгдсэн утасгүй интернэтийн төхөөрөмжийн 6,733.4 мянган төгрөгийн үлдэгдлээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 922,497.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 142,031.9 мянган төгрөг нийт 1,064,529.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 527,492.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,449,990.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 26,413.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 168,445.0 мянган төгрөгөөр, нийт 1,618,435.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,339,890.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 168,445.0 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 116,295.6 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **1,624,630.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 445,432.8 мянган төгрөгөөр,

- Тогтмол зардлыг 26,413.1 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 5,739.1 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 16,683.6 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 24,608.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 35,029.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,456,185.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 168,445.0 мянган төгрөг, нийт 1,624,630.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,423,350.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,423,350.5 мянган төгрөг буюу 87.6 хувьтай байгаа нь байр ашиглалтын үйлчилгээний зардлыг 573.5 мянган төгрөгөөр, хүүхэд хамгааллын зардал 2,220.2 мянган төгрөгөөр, эрүүл мэндийг дэмжих зардлыг 1,050.7 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 3,306.7 мянган төгрөгөөр, дотуур байрны зардлыг 80,081.2 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 5,106.7 мянган төгрөгөөр, бичиг үсгийн боловсролын хөтөлбөрийн зардлыг 9,744.8 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 91,403.2 мянган төгрөгөөр, сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг 1,495.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	1,456,185.6	1,261,200.9	194,984.7	86.6
80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	2,745.9	2,172.4	573.5	79.1
80233 - Хүүхэд хамгаалал	2,470.2	250.0	2,220.2	10.1
80312 - Сургалт семинар	2,182.1	2,182.1	-	100.0
81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,475.7	1,425.0	1,050.7	57.6
81801 - Үдийн цай хөтөлбөр	35,598.8	32,292.1	3,306.7	90.7
81806 - Дотуур байр	218,700.0	138,618.8	80,081.2	63.4
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	27,982.8	27,980.1	2.7	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	6,736.7	1,630.0	5,106.7	24.2
81827 - Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	15,550.5	5,805.7	9,744.8	37.3
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,085,342.5	993,939.3	91,403.2	91.6
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	41,020.7	41,020.7	-	100.0
81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	280.0	280.0	-	100.0
81848-Сурах бичгийн түрээс	2,138.9	2,138.9	-	100.0
81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	2,960.8	1,465.8	1,495.0	49.5
83603- Дээд шатны төсвөөс	10,000.0	10,000.0	-	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	168,445.0	162,149.6	6,295.4	96.3

80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	168,445.0	162,149.6	6,295.4	96.3
ДҮН	1,624,630.6	1,423,350.5	201,280.1	87.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Үдийн цайны материал	43,172.6	43,172.6	ХТШ
2	Дотуур байрны хүнс	33,507.0	33,507.0	ХТШ
	Нийт дүн	76,679.6	76,679.6	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа дараах багцуудад хуваан харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зарласан.

Багц – 1 Мах,

Багц – 2 Хүнсний ногоо,

Багц – 3 Гурил,

Багц – 4 Бусад хүнс,

Багц – 5 Сүү, сүүн бүтээгдэхүүн

Уг шалгаруулалтад "Ханангийн хөх бууц" ХХК, Сүүн дейри ХХК, Бум-Эрдэнэ ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын

сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,003,882.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,058.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 167 мэдээллийг бүрэн мэдээлж, тухай бүр мэдээлэх 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Үүнд: Хугацаа хоцроосон

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 2 удаа,
- Байгууллагын батлагдсан төсөв - 1 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан - 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/54 дүгээр *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,663.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 225.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,438.7 мянган төгрөгийн улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард анги даалтын нэмэгдэл олгосон, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчилд албан шаардлага, шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 80.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	225.2	2	225.2	100.0
Албан шаардлага	2	1,438.7	2	1,438.7	100.0
Зөвлөмж	1	-		-	-
Нийт дүн	5	1,663.9	4	1,663.9	80.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **131,176.5** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд түрээсийн сурах бичгийн 2,061.3 мянган төгрөг, дээд шатнаас хуваарилсан 10,000.0 төгрөгийн санхүүжилт зэрэг нийт 12,061.3 мянган төгрөгийг урсгал санхүүжилтээр тайлагнасан,
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 52,006.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авахдаа үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн,
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,300.0 мянган төгрөгийн үнэ бүхий үкэлэлэ хөгжмийг хөрөнгөд орлого авалгүй шууд зардлаар тайлагнасан,
- Түрээсийн сурах бичгийн 2,061.3 мянган төгрөгийг үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд бараа үйлчилгээний зардлаар тайлагнасан,
- Боловсролын яамнаас “pearson” хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн компьютер, ухаалаг самбар, wifi төхөөрөмж зэрэг нийт 84,997.0 мянган төгрөгийн цахим ангийн хэрэглэгдэхүүнийг 48 сарын хугацаатай лизингээр Мэксим консалтинг ХХК-с авч тайлант онд төлөгдсөн 21,249.2 мянган төгрөгөөр бүртгэснээс санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийн болон үндсэн хөрөнгийн дүн 63,747.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна

Аудитаар нийт 7,626.3 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс 1,193.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах цаашид давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 3 ажилтанд **342.7** мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх *"Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Зайлшгүй шаардлагаар буюу мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас сургалтын менежерт долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр 851.1 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, БШУЯ-ны сайдын 2023 оны А/386 тоот тушаал 1.1 *"Мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас хичээл, сургалтын тасралтгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдолд тухайн сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер болон бусад багш мэргэжилтэй ажилтнаар мэргэжлийн дагуу долоо хоногт 6 хүртэл цагийн хичээл заах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Нярвын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, бүртгэл хөтлөлтөд тавих хяналтыг хэрэгжүүлдэггүй, бараа материалын орлого, зарлагын зарим баримт дутуу, гарын үсгээр баталгаажаагүй, гэрээ, төсөв, хөтөлбөр, цахим төлбөрийн баримт зэргийг дутуу хавсаргасан зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар 6,432.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно"*, 13.7 дахь *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
МГТ-д орлогын ангиллыг буруу бүртгэсэн	2	12,061.3			2	12,061.3	2	12,061.3				
Үнэ төлбөргүй орлогыг буруу бүртгэн тайлагнасан	12	52,006.1			12	52,006.1	12	52,006.1				
Шууд зардлаар тайлагнасан	1	1,300.0			1	1,300.0	1	1,300.0				
Зардлын ангилал буруу бүртгэсэн	1	2,061.3			1	2,061.3	1	2,061.3				
Өр төлбөрийг дутуу бүртгэсэн	1	63,747.8	1	63,747.8			1	63,747.8				
Дүн	17	131,176.5	1	63,747.8	16	67,428.7	17	131,176.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй	1	342.7			1	342.7						

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Сургалтын менежерийн хичээл заах цагийг хэтрүүлсэн	1	851.1			1	851.1				
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэсэн	1	6,432.5					1	6,432.5		
Дүн	3	7,626.3			2	1,193.8	1	6,432.5		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим санд 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-			1	-		
Дүн	1				1	-		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1				1			